МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ИНЭЭМСЭГЛЭЛИЙН ТӨЛӨӨ

ЯПОН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ТЭМДЭГЛЭЛ

Япон улсын НИНЖИН Төрийн бус байгууллагаас ЖАЙКА-ийн Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтнийг чадавхжуулах төсөл”-ийн тайлан-тэмдэглэл

Төсөл хэрэгжсэн хугацаа:
2016/09 - 2019/08

Эрхлэн гаргагч: НИНЖИН Төрийн бус байгууллага
Төслийн багийн гишүүд: Үмэмүра Киёора, Мороиши Марико, Ногүчи Ёоко, Ёшино Наоко, Цүцүми Ёоко, Широ Рёожи, Сүзүки Шигэрү
Эмхэтгэсэн: Үмэмүра Киёора
Орчуулсан: Д.Чимгээ, Т.Энэбиш,
Редактор: С.Батхишиг
Зураач: Н.Сонинбаяр
Эх бэлтгэл: Д.Чимгээ, Б.Төгсжаргал

Вэб: http://www.ninjin-npo.org
И-мэйл: info@ninjin-npo.org
Хаяг: Широ Ортопед эмнэлэг, Кичижоожи, Хончёо 1-21-2-201, Мүсашино, Токио 180-0004
Фэйсбүүк пэйж: Ninjin NPO Нинжин ТББ

ӨМНӨХ ҮГ

НИНЖИН төрийн бус байгууллага 2003 онд байгуулагдсанаасаа хойш Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслах үйл ажиллагаа явуулсаар ирсэн билээ. Тус үйл ажиллагааны нэг хэсэг нь Японд хэрэглэгдэхээ больсон тэргэнцрийг Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүргэх аян юм. Энэхүү аянаар бид хүүхдүүдийг гэрээсээ гарч, хүмүүсийн дунд орж нийгмийн амьдралд оролцоход нь дөхөм болохыг зорьсон. Үүнээс гадна манай байгууллагын гишүүд болох эмч, хөдөлгөөн засалч, багш зэрэг бүрэлдэхүүнтэй баг жил бүр Монголд богино хугацаагаар очин үзлэг зөвлөгөө явуулж байв. Бид Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөж торних орчныг бага ч болов сайжруулахын төлөө чармайж ирсэн. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрхэн өсгөх, хөгжүүлэх, харилцах талаарх ойлголт хүмүүст сул хэвээр байгааг бид анзаарсан юм. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн өсгөх тухай зааж, эдгээр хүүхдүүдтэй ойр ажилладаг, тусламж үйлчилгээ үзүүлдэг хүмүүст ч мэдлэг мэдээлэл түгээхээр шийдсэн билээ. Улмаар 2016 оны 9-р сард ЖАЙКА-ийн Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтнийг чадавхжуулах төсөл”-ийг эхлүүлсэн билээ. ЖАЙКА-ийн санхүүжилтээр төслийн багийн гишүүд нэгэн зорилгын төлөө хичээн зүтгэсэн бөгөөд гурван жилийн хугацаанд олон олон сайн үр дүн, амжилтыг үлдээж 2019 оны 8-р сард төсөл дууссан юм. Монгол хэл дээрх энэхүү тайланг боловсруулах төлөвлөгөө анх байгаагүй боловч, төслийн үр өгөөж, сайн жишээг олон хүнд хүргэх нь зүйтэй гэж бид үзсэн.

Төсөл хэрэгжсэн "Сайн найз", "Гэгээлэн" төвийн үйл ажиллагаа улам тогтвортой болж байна. Төслийн хугацаанд, мөн өдийг хүртэл халуун сэтгэлээр зүтгэсэн Монгол талын хамтрагч нартаа халуун талархал дэвшүүлье. Мөн төслийн нийт гишүүддээ дахин талархал илэрхийлье.

Сүүлийн үед Монголд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хууль тогтоомжууд боловсронгуй болж, хөдөлгөөн засал, хөдөлмөр заслын мэргэжилтэн бага багаар нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгох тал дээр ахиц дэвшил гарч байна. Үүнийг дагаад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих орчин ч улам сайжрах болов уу хэмээн бид найдаж байна. Гэвч хүүхдийн хөдөлгөөн заслын тухайд авч үзвэл мэргэжилтэн, орчин нөхцөл дутуу дулимаг хэвээр байна.

Японд Такаги Кэнжи (1888-1963) эмч “Шинжлэх ухааны бүх салбарын нэгдсэн хүчин чармайлтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өсгөх” буюу “Рёоикү” (療育* монгол хэлнээ “Хөгжлийн дэмжлэг” гэж орчуулж байна) хэмээх ойлголтыг дэвшүүлсэн нь өдгөө Япон даяар дэлгэрэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих суурь хандлага болж байна. Монголд ч ялгаагүй цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөж хөгжих орчныг монголчууд өөрсдөө гар бие оролцон боловсронгуй, хүртээмжтэй болгож, хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд идэвхтэй, бүрэн дүүрэн амьдралыг туулж өнгөрүүлээсэй хэмээн хүсэж байна. Энэхүү тайлан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, тэдгээр хүүхдүүдтэй ойр ажилладаг, харилцдаг хүмүүст хэрэгтэй гарын авлага болох аваас бид ихэд баярлах болно.

НИНЖИН ТББ-ын тэргүүн
Широ Рёожи

2019 оны 9-р сар. Хөгжлийн бэрхшээлтэй
хүүхэдтэй эцэг эхийн холбооны төв оффист

ТӨСЛИЙН БАГИЙН ГИШҮҮД

Умэмура Киёора (Төслийн удирдагч, Хүүхдийн эмч)

Мороиши Марико (Хөдөлгөөн засалч)

Ногүчи Ёоко (Тусгай сургуулийн багш)

Ёшино Наоко (Цэцэрлэгийн багш)

Цуцүми Ёоко (Хөдөлмөр засалч)

Широ Рёожи (Ортопед-согог зүйч эмч)

Сүзүки Шигэрү (Санхүү хариуцагч, Нийгмийн халамжийн салбарт ажиллаж байсан)

2019 оны 12-р сар. Токио хот дахь ЖАЙКА-ийн
төв оффис, төслийн тайлангийн хурлын дараа

ГАРЧИГ

1 "ӨВСНИЙ ҮНДЭС" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

- Төсөл хэрэгжсэн явцын тойм 8
- Хоёр төвийн эцэг эхчүүдийн өөрчлөлт 12
- ГЭГЭЭЛЭН төв, САЙН НАЙЗ төв 14

2 ТӨСЛИЙН БАГИЙНХНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТАРХИНЫ САЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ 16
МОРОИШИ МАРИКО (Хөдөлгөөн засалч)
"Гэгээлэн", "Сайн найз" төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлсэн хөгжлийн дэмжлэг, хөдөлгөөн заслын арга барил 20
- Ганцаарчилсан зөвлөгөө, удирдамжийг хэрэгжүүлсэн жишээ 21
- НИНЖИН-Өвсний үндэс өдрийн зорилго, агуулга 24

ХҮҮХДИЙНХЭЭ ЖИЖИГ АМЖИЛТ БҮРИЙГ АНХААРЧ, УРАМ ӨГӨӨРЭЙ 28
НОГУЧИ ЁОКО (Тусгай сургуулийн багш асан)
- Тоо заах дараалал 30

ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШИЙН ТЭМДЭГЛЭЛ 32
МАЦУМОТО НАОКО (Сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн багш)
- Цөөн хүний бүрэлдэхүүнтэй сургалт, хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр 32
- Гарын доорх материалаар тоглоом хийцгээе 34

ЗУРАГТ НОМ УНШИЖ ӨГӨХ 37
УМЭМУРА КИЁОРА (Хүүхдийн эмч)

ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГИЙН ДЭВТЭР 39
УМЭМУРА КИЁОРА (Хүүхдийн эмч)

3 ТӨСЛӨӨС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, ЛЕКЦ

1. Хөдөлгөөн заслын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, дадлага ажил 42
2. Өрхийн эмч, сувилагч нарт зориулсан сургалт 43
3. Эцэг эхчүүдэд зориулсан сургалт 44

Төгсгөлд нь
Төсөл дууссаны дараа

1

ӨВСНИЙ ҮНДЭС ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ЯВЦЫН ТӨЙМ

Төслийн удирдагч УМЭМУРА КИЁОРА

ТӨСӨЛ ЭХЭЛСЭН НЬ

Төслийн багийн гишүүд бид 2016 оны 9-р сард төсөл эхэлсний дараа “Сайн найз”, “Гэгээлэн” төвд очсон юм. Энэхүү хоёр төвийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хоёр ээж үүсгэн байгуулсан. Тэд “Хүүхэдтэйгээ багаас нь зөв харилцах, тохиромжтой арга барилаар өсгөх тухай мэддэг чаддаг бүхнээ бусад ээж аав нартай хуваалцах” ундарсан хүсэл эрмэлзэлтэйгээр биднийг угтсан билээ.

Төслийн эхэн үед олон эцэг эх **“Япон эмч нар хүүхдийг маань эдгээх байх”** хэмээн биднээс **“эмчилгээ”** хүсэн хүлээж байв. Зарим ээж нар “Манай хүүхэд эдгэх үү” гэж шуудхан асуудаг байлаа. Тархины саажилт бол эмчилгээгээр эдгээхэд тун хэцүү өвчин билээ.

“Хүүхдэд таарсан хөгжлийн дэмжлэг, сурах арга барилын талаар ойлгож мэдээд, өдөр бүр тууштайгаар тэрхүү арга барилуудыг хэрэгжүүлээрэй. Хүүхдээ цэцэрлэг, сургуульд хамруулаарай.”

Бид эцэг эхчүүдийн асуултад ийн хариулдаг байв. Зарим ээж аавын хувьд үүнийг хүлээн авахад хугацаа шаардлагатайг бид ойлгож байлаа.

Төслийн багийн гишүүн, хөдөлгөөнзасалч Мороиши Марико төсөлд хамрагдсан тархины саажилттай хүүхэд нэг бүрд хэд хэдэн удаа нарийн үзлэг хийж, гэрт хийх дасгал, хөгжлийн дэмжлэгийн арга барилыг эцэг эхэд нь зааж өгдөг байв. Тусгай сургуулийн багш байсан Ногучи Ёоко төв дээр ирсэн өдрөө хүүхдүүдэд тоо, өнгө, дүрс зэргийг зааж байлаа. Хэн хэн нь Японд олон жил ажиллаж арвин туршлага хуримтлуулсан мэргэжилтэн билээ.

2018 оны 9-р сараас цэцэрлэгийн багш мэргэжилтэй Ёшино Наоко төслийн гишүүн болсноор хүүхдүүдийг бүлгээр нь нэг дор хэрхэн хөгжүүлэх тухай, гэрийн нөхцөлд гар доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүн хийх талаарх мэдлэг туршлагаасаа эцэг эхчүүдтэй хуваалцсан. Ёшино багш 2016 оны 2-р сараас ЖАЙКА-ийн сайн дурын ажилтан болж Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэршээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоонд ажилласан бөгөөд монгол хэлийг маш сайн эзэмшсэн нэгэн юм. Эдгээр гурван мэргэжилтэн төслийн хугацаанд хэрхэн ажилласан талаар 2-р хэсгээс уншаарай.

Бид 2019 оны 8-р сар хүртэл 3 жилийн хугацаанд нийт 8 удаа Монголд ирж ажилласан. Нэг удаад 14 хоногоор ирж, хоёр төв дээр хүүхдүүд, эцэг эхчүүдтэй ажиллахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүд, хөдөлгөөн засалч, эмч, сувилагч, цэцэрлэг, дунд сургуулийн багш, асрагч зэрэг хүмүүст зориулан лекц сургалт зохион байгуулж байв.

Тус төсөлд орчуулагчаар ажилласан Д.Чимгээ, Ё.Оюунгэрэл нар биднийг хоёр төв дээр ажиллахад орчуулга хийж, мөн лекц-сургалт зохион байгуулахад тусалсан. Түүнчлэн төсөл сайн хэрэгжихэд тустай боловч бидний анзаараагүй зүйлс, монголчуудын тухай бидний мэдэх ёстой, ойлгох ёстой зүйлсийг хэлж өгдөг байв.

Монголд маш өргөн хэрэглэгддэг нийгмийн сүлжээ болох фэйсбүүк дээр төслийн пэйж хуудсыг нээж, лекц-сургалтуудын талаар мэдээлэл оруулдаг байв.

НИНЖИН-ӨВСНИЙ ҮНДЭС ТӨСЛИЙН ӨДӨР

Төсөл эхлээд удалгүй өвөлтэй золгов. Олон хүн цугладаг төвийн байр дулаахан байх шаардлагатай. “Гэгээлэн” төвийн нүүрсний зардал, галчийн цалинг хорооноос нь гаргахаар болов. “Сайн найз” төв хашаандаа том гэр барьж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байв. Удалгүй нэгэн олон улсын байгууллагын тусламжаар төвийн барилга халаалттай болов.

Хөдөлгөөн засалч маань төсөлд хамрагдсан хүүхэд бүрд дасгалын цэс боловсруулж өгсөн. Гэвч эцэг эхчүүд ажил хөдөлмөр эрхлэх, бусад хүүхдээ асраад цаг зав багатай тул хөдөлгөөн засалчийн зөвлөсөн дасгалд зарцуулах цаг хомс байсан. Мөн дасгалыг зөв буруу хийж байгаа эсэх талаар зөвлөгөө авах боломжгүй байв. Тиймээс төслийн хөдөлгөөн засалч Мороиши сард нэг удаа видео дуудлагаар төвтэй холбогдон ээж аав нарт зөвлөгөө өгөхийг хичээсэн ч дэлгэрэнгүй, хувьчилсан зөвлөгөө өгөхөд хангалтгүй байв.

2017 оны намраас бямба гараг бүрийг “Нинжин-Өвсний үндэс төслийн өдөр” гэж нэрлэн төвийн хүүхдүүд эцэг эхийн хамт төв дээр цуглан хөдөлгөөн заслын дасгал хийх, хичээл хийх, зурагт ном унших, эцэг эхчүүд мэдээллээ солилцох, ярилцах зэргээр цагийг үр дүнтэй өнгөрүүлэх болов. Үдийн хоолны цагаар жижүүр ээж нарын бэлтгэсэн хоолыг бүгд амтархан иддэг. Төслийн төсөвт багтаагүй хоолны материалын зардлын зарим хэсэг, жижүүр ээжийн унааны мөнгө зэргийг төслөөс гаргах болов. Төсөл болон хоёр төвийг холбох үүрэгтэй орчуулагч нар сард нэг удаа энэ өдөрт оролцож хөдөлгөөн засалчийн зөвлөгөөг дамжуулах, хүүхдүүдэд зурагт ном уншиж өгөх зэргээр тусалдаг байв.

Хүүхдүүд энэ өдөр төв дээрээ маш олон ном уншуулж, өөрсдөө ч уншдаг бөгөөд шинэ жилийн баяраар тэд хамгийн дуртай “Манжингийн үлгэр” номоороо жүжиг тоглосон юм.

Төвийн ээжүүд төслийн хүрээнд “Нинжин-Өвсний үндэс төслийн өдөр”-өөс тусдаа сард нэг удаа цуглан мэдээлэл солилцох цагтай болсон. Уг уулзалтад аав нар ч оролцдог. Энэхүү цугларалт эцэг эхчүүдийн хувьд сэтгэлээ уудалж ярилцах чухал цаг болсон юм. 2019 оны 8-р сард төсөл дууссан ч хоёр төв дээр бямба гараг бүр “Нинжин-Өвсний үндэс төслийн өдөр” болсоор байна.

ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСАЛДАГ САЙН ДУРЫНХАН

Бямба гарагаас бусад өдрүүдэд ч сайн дурын оюутнууд хоёр төвд ирж үйл ажиллагаанд тусалдаг. “Сайн найз” төвийн хүүхдүүд хөл бөмбөгийн баг үүсгэн тогтмол бэлтгэл сургуулилт хийдэг. Үүний үр дүнд 2019 онд Тайванд зохион байгуулагдсан Тусгай олимпын эрх авах тэмцээнд багаараа оролцжээ. Багийн дасгалжуулагч ч мөн “Сайн найз” төвд сайн дураар тусалдаг хүн юм.

“Гэгээлэн” төвд Монголын Хүүхдийн ордны зургийн багш тогтмол ирж зургийн дугуйлан хичээллүүлж байна. Ийнхүү дүн өвлийн хүйтэнд ч хоёр төвд олон хүүхэд, эцэг эхчүүд цуглан цагийг үр бүтээлтэй, идэвхтэй өнгөрүүлж байна.

ГУРВАН ТӨРЛИЙН СУРГАЛТ, САЛБАРЫНХАНТАЙ НЭТВОРКИНГ

Бид төслийн хүрээнд зөвхөн хоёр төвийг дэмжээд зогсохгүй, мэдлэг туршлагаа илүү өргөн хүрээнд түгээхийн тулд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан сургалт”, “Хөдөлгөөн засалч зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалт”, “Өрхийн эмч, сувилагч нарт зориулсан сургалт”-ыг зохион байгуулсан. Зарим сургалтаар ортопед эмч Широ Рёожи, мэдрэл, дотрын эмч Огова Кацухико нар анагаахын нарийн мэргэжлийн лекц ч орсон юм. Сургалтад оролцогчдоос “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар шинэ мэдлэг, мэдээлэл авлаа”, “Хөдөө орон нутагт заавал ирж сургалт зохион байгуулаарай” гэх өндөр үнэлгээ авсан бөгөөд Хэнтий, Өмнөговь, Дорнод зэрэг аймгаас зорьж ирэн сургалтад оролцсон хүмүүс ч байсан юм.

Монгол улсад 2007 оноос АШУҮИС дээр хөдөлгөөн засалч бэлтгэх анги нээгдсэн бөгөөд 2018 оноос мэргэжлийн лицензийн шалгалт авч эхэлсэн. Гэвч уг мэргэжлээр бэлтгэгдэж буй хүн цөөхөн хэвээр бөгөөд хүүхдийн хөдөлгөөн засалд дөнгөж анхаарч эхэлж байна.

Бид хоёр төв рүү хөдөлгөөн засалч томилуулж ажиллуулах талаар холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнуудтай уулзаж ярилцаж, хүсэлт хүргүүлсэн боловч хүний нөөцийн хүрэлцээ хангалтгүйн улмаас нааштай шийдэгдээгүй билээ.

2018 оны 10-р сараас төслийн хүрээнд АШУҮИС-ийн Хөдөлгөөн заслын мэргэжлийн 4-р курсийн оюутнууд бямба гараг бүр хоёр төвд ирж сайн дурын ажил хийх болсон ба манай байгууллагаас эдгээр оюутнуудад сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон тухай батламжийг 2019 оны 5-р сард гардуулсан. Эцэг эхчүүд, хүүхдүүд ч оюутнуудын сайн дурын ажилд талархалтай байсан. Оюутнуудын хувьд ч хүүхдүүдтэй ажилласан туршлага нь цаашид мэргэжлээрээ ажиллахад гарцаагүй хэрэг болох юм.

ТӨСЛИЙН АМЖИЛТ, ЦААШИД ХЭРХЭХ ТУХАЙ

Уг төслийн хамтрагч болох Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн С.Сэлэнгэ “Энэ төсөл 'Хүүхдэд маань ирээдүй байхгүй' хэмээн цөхөрч байсан ээж аав нарт 'Хүүхэд тань нийгмийн амьдралд оролцож чадна' гэж ойлгуулахад их хувь нэмэр оруулсан” гэж үнэлсэн юм.

Нэгэн ээж “Бага хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй төрөхөд энэ хүүхдэд ирээдүй байхгүйгээс хойш ах эгч нарынх нь боловсролд нь мөнгөө зарцуулах юм шүү, гэж бодсон ч НИНЖИН-ийн төсөлд оролцоод энэ үзэл бодол маань өөрчлөгдсөн” гэж үнэн сэтгэгдлээ бидэнд хэлж байв. Өдгөө тэрээр цэцэрлэгээс бага сургуульд дэвшсэн бага хүүхдийнхээ ирээдүйд гэрэл гэгээ байгаа гэх итгэл найдвартай болсон.

Монгол улсад 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдаж 2020 он хүртэлх 4 жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгсдийн нийгмийн оролцоог тал бүрээр хангах бодлогыг хэрэгжүүлж байна. Улсын цэцэрлэгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг заавал элсүүлэх үүрэгтэй болж, энэ хуулийн хэрэгжилт 2019 оноос улсын бага сургуульд ч хамааралтай болсон. Цэцэрлэг, сургууль бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй болоход хөрөнгө, цаг хугацаа шаардлагатай нь ойлгомжтой. Юутай ч нэгэн эмээгийн “Миний ач охин цэцэрлэгт элсэх эрхтэй” хэмээсэн үг Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах, сурч хөгжих орчинд шинэ салхи гарч байгааг бидэнд мэдрүүлсэн билээ.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ХӨЁР ТӨВИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮД, ХҮҮХДҮҮДЭД ДАРААХ ӨӨРЧЛӨЛТҮҮД АЖИГЛАГДСАН

Монголд “Тархины саажилт эмчлэгддэг” гэдэг ойлголтоор хүүхдээ уламжлалт эмчилгээ зэрэг төрөл бүрийн эмчилгээнд явуулдаг эцэг эх олон байдаг.

2007 онд АШУҮИС-д хөдөлгөөн засалчийн анги нээгдсэн бөгөөд 2018 оныг хүртэл 147 хүн төгсжээ. Тэдний ихэнх нь насанд хүрэгчдийн хөдөлгөөн заслаар мэргэшсэн тул хүүхдийн хөдөлгөөн засалч дутагдалтай хэвээр байгаа юм. Тиймээс хүүхдийн хөдөлгөөн заслын үйлчилгээг Сэргээн засалт хөгжлийн үндэсний төв болон дүүргийн эмнэлгүүдэд очиж байж л авдаг. Хоёр төвийн эцэг эхчүүд тэдгээр эмнэлэгт очоод хязгаарлагдмал цагаар ч болов хөдөлгөөн засалчид хүүхдээ даатган “эмчилгээ хийлгэдэг” гэх хандлагатай байв. Харин манай төслийн баг тархины саажилтыг “эмчлэх” бус, биеийн байрлал, хөдөлгөөнийг зөв хянах, хооллолтын арга техникийг сайжруулах талаар арга зүйн зөвлөгөө өгч, өдөр тутмын амьдрал дунд хүүхдийг хөгжүүлэх боломжтой дасгал хөдөлгөөн, тоглоомыг эцэг эхчүүдэд зааж өгсөн юм. Хөдөлгөөн засалч дээр очоод бүгдийг хийлгэх биш, өдөр бүр гэртээ дасгал хийхийн чухлыг бид эцэг эхчүүдэд ойлгуулахыг хичээж мэдлэг мэдээллээ хуваалцсан. Тухайлбал, “Тархины саажилттай хүүхдийн асаргаа: Хөдөлгөөн”, “Тусгай хэрэгцээт хүүхдийн асаргаа: Хооллолт” гарын авлага, “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хооллолт” видео хичээлийг эцэг эхчүүдэд хүргэсэн.

Анх төсөл эхлэхэд “Тархины саажилт эдгэдэггүй” гэж сонсоод сэтгэлээр унасан ээж аав нар ч Нинжин-Өвсний үндэс төслийн өдөрт тууштай оролцсоор тархины саажилтыг “засаж эмчлэх” бус “гэртээ ч хөгжлийн дэмжлэгийг тууштай хэрэгжүүлж хүүхдээ өсгөхийн чухлыг, энэ хандлага, ойлголтыг бусад ээж аав нарт ч хэлж, дэлгэрүүлэх хэрэгтэйг ойлгож эхэлсэн.

Төсөлд хамрагдсан сургуулийн насны хүүхдийн 80 хувь нь сургуульд (энгийн, тусгай сургууль нийлээд) явдаг. Хоёр төвийн хүүхдүүд төслийн гишүүн Ногүчи багшийн бэлдсэн тооны дасгалыг маш идэвхтэй хийж байсан. Заримдаа ойлгохдоо удаан, буруу боддог ч тэд хичээл хийх маш дуртай. “Хичээл хийх гоё байна уу?” гэх асуултад зарим хүүхэд “Яагаад ийм мэдээжийн, ойлгомжтой юм асуугаад байгаа юм бэ” гэж хариулдаг. Тусгай боловсрол шаардлагатай хүүхэд бүрд ойлголтынх нь түвшинд тохируулсан сургалтын агуулга, төлөвлөгөө байх ёстой.

НИНЖИН ТББ-аас хоёр төвд 100 гаруй ном бэлэглэсэн. Зурагт номыг маш баяр хөөртэйгөөр уншуулах хүүхдүүдээ хараад эцэг эхчүүд ч зурагт номын ач холбогдлыг улам сайн ойлгосон билээ. Ээж аав нь хүүхдээдээ, том хүүхдүүд нь багачуудаа ном уншиж өгөх нь хоёр төвийн нэг чухал дадал болжээ. Мөн

бид Японы онцгой соёл болох Камишибай буюу цаасан театрыг хоёр төвийн хүүхдүүдэд уншиж өгдөг байв. Нэгэн аав камишибай уншихад зориулан модон жааз хүртэл хийж өгсөн. Зурагт ном хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй бүх л хүүхдийн хувьд танин мэдэхүйг нь тэлж, туршлага нэмж, олон олон үүд хаалгыг нээж байдаг. Мөн харилцааны гүүр болдог. Би монгол хэл сурч байгаа ч дуудлага муутай тул "Гэгээлэн" төвд очсон үедээ нэгэн сурагч охинтой хамт зурагт ном уншин дуудлагаа сайжруулах дасгал хийдэг байлаа.

"Сайн найз" төв хандиваар ном цуглуулан уншлагын танхим нээхээр төлөвлөж байна.

2018 оны 9-р сараас цэцэрлэгийн багш Ёшино Наоко төслийн багт шинээр орсон. Тэрээр олон хүүхэдтэй бүлэгт сургалт, хүмүүжлийн цагийг хэрхэн явуулах жишээг хоёр төвийнхөн болон ээж аав нарт харуулсан юм. Хүүхдүүд анхандаа тайван сууж чадахгүй, төвлөрөхгүй байсан бөгөөд Ёшино багш гэрт болон төв дээр ашиглаж болох олон сонирхолтой сургалтын хэрэглэгдэхүүнийг ээж аав нарт зааж өгсөн. Хүүхдүүд төв дээр ирж хамт олны дунд орж тоглохоос гадна, гэртээ тоглонгоо сурч хөгжих боломжтойг аав ээж нарт мэдрүүлсэн юм.

Хүүхдийнхээ оношийг сонссоноосоо хойш нийгмээс тусгаарлагдаж, хаана хандаж зөвлөгөө авахаа сайн мэдэхгүй байсан ээж аав нар хоёр төв дээр ирж Нинжин-Өвсний үндэс төслийн өдөрт оролцох болсноор хүмүүсийн дунд орж, бусад ээж аав нартай жаргал зовлонгоо хуваалцан, шинэ мэдээлэл авах боломжтой болсон. Хүүхдүүд ч төв дээр олон найзтай болж, нэг ангийнхан мэт болсон билээ.

Төсөл 2019 оны 8-р сард дууссан ч хоёр төвийн цаашдын тогтвортой үйл ажиллагаанд нэмэр болохын тулд бид бямба гараг бүрийн НИНЖИН-Өвсний үндэс өдрийн хоолны материалын зардал, сард нэг удаа төвд ирдэг хөдөлгөөн засалч, орчуулагчийн ажлын хөлсийг дааж байна.

2019 оны 4-р сар. Төслийн тайлангийн хуралд
Гэгээлэн төв, Сайн найз төвийн хүүхдүүд, эцэг эхчүүд оролцов.

ГЭГЭЭЛЭН ТӨВ, САЙН НАЙЗ ТӨВ

НИНЖИН ТББ-ын Өвсний үндэс төслийн багийнхны 2016 оноос хойш дэмжиж ирсэн "Гэгээлэн" төв, "Сайн найз" төв нь Улаанбаатар хотын захын гэр хороололд байрладаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд 2014 онд өөрсдийн санал санаачилгаар уг хоёр төвийг байгуулж, ойр хавийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний гэр бүлүүдийг оролцуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм.

Удирдлага: Ц.УЯНГА

Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг,
16-р хороо, Өрхийн эмнэлгийн хажууд

Фэйсбүүк хаяг: Chingeltei Gegeelen Tuv

Утас: 8002-4665

Удирдлага: Ж.АЛТАНТҮЛХҮҮР

Хаяг: УБ хот, Баянзүрх дүүрэг,
17-р хороо, Эрдэнэ-Толгой 35-924

Фэйсбүүк хаяг: Сайн найз

Утас: 8955-5755

2

ТӨСЛИЙН БАГИЙНХНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТАРХИНЫ САЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ

МОРОИШИ МАРИКО *(Хөдөлгөөн засалч)*

ТӨСӨЛ ЭХЛЭХЭЭС ӨМНӨ

Миний бие энэ удаагийн төслөөс өмнө 2012 онд НИНЖИН ТББ-аас хэрэгжүүлсэн “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслах эмч, мэргэжилтнүүдийн баг”-т орж 2015 оныг хүртэл жилд нэгээс хоёр удаа Монголд ирдэг байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдтэй уулзах бүрд тэд “Хүүхдээ тусалмаар байна, яавал дээр вэ” гэж асуудаг байлаа. Нэг гэр бүлтэй нэг л удаа уулзаж зөвлөгөө өгөх боломжтой тул тухай бүрд нь хариулт өгөхөөс өөр аргагүй. Гэвч хүүхэд нь таталт (эпилепси) өгч шөнө нойргүй хонодог эцэг эхчүүд ч бидэнд ханддаг байсан ба ганц уулзалтаар дээрх шиг хүнд асуултад бүрэн дүүрэн хариулах боломжгүй байв.

“Хүүхэд маань булчингийн чангарлаасаа болоод хэвийн байрлалд сууж, хэвтэж чадахгүй байна”, “Ганцаараа сууж чадахгүй байна” гэж сэтгэл нь түгшсэн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ зөв хооллож сурах шаардлагатай эцэг эхтэй олон таарч байв. Тэдэнд нэн шаардлагатай арга барилыг зааж, тэдгээр арга барил, дасгалыг гэртээ хэрэгжүүлж хэвшихэд сургаж, түгшүүрээ даван туулахад нь туслахыг зорьсон. Гэвч нэг удаагийн үзлэг зөвлөгөөгөөр асуудлыг шийдэх боломжгүй юм.

ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГИЙН АРГАЗҮЙН ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХООР ЗОРЬСОН НЬ

Гэрийн нөхцөлд дасгал хөдөлгөөн хийлгэхэд гэр бүлийн оролцоо, чармайлт чухал.

2016 онд НИНЖИН ТББ ЖАЙКА-ийн Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх болж, уг төслийн хүрээнд 3 жилийн хугацаанд 8 удаа Монголд ирж ажиллах боломж надад олдсон юм. Өмнө нь нэг хүүхдийг нэг л удаа үздэг байсан бол энэ төсөл хэрэгжсэнээр нэг хүүхдийг 8 удаа үзэх, эцэг эхчүүдийн хэрэгцээ, шаардлагад илүү сайн хариулах боломж бүрдсэн билээ. Мөн хоёр төв дээрх адилхан бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдийг групп болгон хамтад нь дэмжиж, зөвлөгөө өгөх боломж бий болсон юм.

“Сайн найз”, “Гэгээлэн” төвийг үүсгэн байгуулсан Ж.Алтантүлхүүр, Ц.Уянга нар тархины саажилттай хүүхдээ асрахын хажуугаар хүүхдийн хөдөлгөөн заслын талаар ойлголт мэдлэг, арга барилд суралцаж, өөрөө хүүхэд асаргаандаа хэрэгжүүлэхээс гадна бусад ээж аав нарт туслах хүсэлтэй гэдгээ илэрхийлж байлаа.

Хүүхдүүд төв дээр дасгал хөдөлгөөн хийж, найз нартайгаа тоглон цагийг хөгжилтэй өнгөрүүлэх орчныг ээж аав нар хамтдаа санаачлан бүрдүүлж байв. Ингэх явцдаа тэд дотно нөхөрлөж, туршлагаа харамгүй хуваалцаж, хүүхэд асрахад тулгардаг бэрхшээлийн талаар ярилцах болж, төв тэдний хувьд харилцан сэтгэлээ уудлах газар нь болсон.

Гэр хороололд амьдралын боломж тааруу айл өрх олон амьдардаг. “Гэгээлэн” төвд саажилттай хүүхдийн сунгалтын дасгал хийх аргыг сурч аваад гэртээ хийхийг хүсдэг нэгэн ээж бий. Гэвч тэрээр бага насны хүүхдүүдээ асрах, гэр орны ажилд дарагдан цаг гаргаж чаддаггүй байв.

Групп дасгалын цаг: Сунгалтын дасгал

Ганцаарчилсан зөвлөгөө

Эцэг эх нь хоёулаа ажил эрхэлдэг гэр бүлд эмээ өвөө нь ач зээгээ дагуулан төвд тасралтгүй ирж, дасгал хөдөлгөөн заалгаж сураад гэртээ очоод хийж хэвшүүлэх зэргээр хичээл зүтгэл гаргасаар байсан. Хүүгээ нэг ч таслуулалгүй байнга төв рүү зөөж "Ганцаарчилсан дасгал", "Багаар хийх дасгал, хөгжөөнт дасгал"-ын үед идэвхтэй оролцдог ганц бие аав ч байлаа.

"Сайн найз" төвийн хувьд, хүүхдээ Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолбор болон хувийн цэцэрлэгт явуулангаа "Сайн найз" төвийн үйл ажиллагаанд ч хамруулах хүсэлтэй гэр бүл цөөнгүй байсан. Ээж аав нар ч өөр хоорондоо туршлагаа солилцохын тулд төв дээр өөрсдөө зорьж ирдэг болжээ.

СУРГАЛТ, ДАДЛАГА АЖИЛ

Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн засал, тусламж үйлчилгээг тасралтгүй явуулахад хүүхдийн мэргэшсэн хөдөлгөөн засалч болон цэцэрлэгийн багш зайлшгүй шаардлагатай. Монголд 2007 оноос хөдөлгөөн засалчдыг бэлтгэх тэнхим бий болж 2010 оноос анхны төгсөгчид төгсөн гарчээ. Гэвч өнөөг хүртэл хүүхдийн хөдөлгөөн заслын талаарх мэргэжлийн хичээлийн хөтөлбөр байхгүй, хүүхэдтэй ажиллах дадлага ажлын кредит хангалттай бус бөгөөд насанд хүрсэн хүний хөдөлгөөн засал зонхилж иржээ.

Миний бие 2012 оноос Монголд ирэхдээ Эх нялхсын эмнэлэг (ЭХЭМҮТ) дээр сургалт зохион байгуулж, дээрх төгсөгчдөд тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн заслын арга барилын тухай заасан.

Харин энэхүү төслийн хүрээнд эцэг эхчүүд, хөдөлгөөн засалч нарыг чадавхжуулах зорилгоор 7 удаагийн сургалт зохион байгуулсан.

Нийслэл болон хөдөө орон нутагт хөдөлгөөн засалчийн хэрэгцээ их байгаа ч уг мэргэжлээр төгсөгч цөөн тул хөдөлгөөн засалчаар ажиллаж байгаа хүмүүсийн дийлэнх нь энэ чиглэлээр мэргэшээгүй, өөр мэргэжлийн хүн байна.

Бидний зохион байгуулсан цуврал сургалтын нэг удаад нь дунджаар 30 хүн хамрагдаж байсан ба тэдний 70 орчим хувь нь хөдөлгөөн заслаар мэргэшээгүй байв. Сургалтад оролцогчид хүүхдийн хөдөлгөөн заслын талаар анхан шатны мэдлэгтэй болж, өнөөг хүртэл баримталж ирсэн хөдөлгөөн заслын арга барилдаа алдаа дутагдал бий эсэхийг нягтлан үзэх хүсэлтэй гэж байлаа.

Оролцогчдод "Гэгээлэн", "Сайн найз" төвд очиж сургалтаар олж мэдсэн арга барилыг дадлага ажлаар бататгах боломж бүрдүүлсэн. Дадлага ажилд оролцохоор зорин ирэгсэдийн дийлэнх нь мэргэжлийн хөдөлгөөн засалч бус хүмүүс байв. Мэргэжлийн эрхтэй хөдөлгөөн засалч нар "онолын мэдлэгтэй л болчихвол хийж чадна" гэж боддог ч байж мэднэ. Тийм хандлагатай хөдөлгөөн засалчид эцэг эхчүүд итгэл үзүүлэхгүй, хүүхэд ч сэтгэлээ нээж хүлээн авахгүй байх талтай.

7 удаагийн цуврал сургалтаар тодорхой сэдвүүдийн хүрээнд үндсэн мэдлэг олгох, хөдөлгөөн засал, хооллолт, асаргааны арга барилыг хүүхэд оролцуулсан демо-бодит жишээгээр зааж сургахад ихээхэн анхаарсан. Харин “Хэвшсэн буруу ойлголтууд”-ын талаар сургалтын дараа санал бодлоо солилцох боломж бүрдүүлж чадаагүйдээ харамсаж байлаа.

Монгол дахь мэргэшсэн хөдөлгөөн засалч, мэргэжилтнүүд цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхтэй тулж ажиллах явцдаа ээжаав нарт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг ойлгож, хүүхдүүдээс өөрсдөөс нь суралцах хандлагаар ажилдаа хандаж, мэргэжлийн ур чадвараа улам сайжруулна гэдэгт итгэж байна.

Сургалтын үеэрх демо

Сургалтын дараа төв дээрх дадлага

"ГЭГЭЭЛЭН", "САЙН НАЙЗ" ТӨВИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДЭД ҮЗҮҮЛСЭН ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ, ХӨДӨЛГӨӨН ЗАСЛЫН АРГ БАРИЛ

Гурван жилийн туршид хэрэгжүүлсэн ганцаарчилсан зөвлөгөөний зорилго ба агуулга

(1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ өсгөж буй эцэг эхчүүдэд (асран хамгаалагчдад) зөвлөгөө өгч, тэдний айдас түгшүүр, хөгжлийн бэрхшээлийг хүлээн зөвшөөрөх шаналал, "хүүхдээ ямар ч аргаар хамаагүй туслах юм сан" хэмээх итгэл найдвар зэрэг сэтгэлзүйн олон нөхцөл байдлыг нь сонсож хуваалцан, тэднийг ойлгох.

(2) Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, бие бялдрын өсөлт хөгжлийг үнэлж "Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл"-ийн талаар эцэг эхчүүдэд ойлгуулахын тулд тайлбарлаж, зөвлөгөө өгөх

Тайлбарлах гол зүйлс, тайлбарлахдаа анхаарах зүйлс:

1/ Хүүхдэд тулгарч буй бие махбодын бэрхшээлийн тухай:
Жишээлбэл: Ганцаараа сууж чадахгүй байх тухай

2/ Хүүхдийн өвөрөө чадаж байгаа зүйлс
Жишээлбэл: Их биеийг нь түшиж дэмжиж өгвөл суугаад тоглодог эсэх

3/ Шинээр юу сургах талаар тайлбарлах
Жишээлбэл: Түрүүлгээ харсан байрлалаар тоглонгоо дөрвөн хөллөж сурах
- Эдгээрийг сургах нь юуны бэлтгэл болдог, яагаад шаардлагатайг тайлбарлах. Дээрх жишээний хувьд, татах хүчний эсрэг дөрвөн мөч, нуруу, их биеэ хөдөлгөх болон (гарын шуугаар биеэ тулж түрүүлгээ харсан чигээрээ толгойгоо өргөх) тэнцвэрээ хадгалж сурахын бэлтгэл болно.

4/ Өөрчлөлт буюу гажгийг (жишээлбэл: доод мөч чангарч хөлөө солбидог) тэр чигээр нь орхивол хатангиршил, хэлбэр алдагдал зэрэг (хоёрдогч эмгэг) үүсэх тухай тайлбарлах: Хөлийн шагайны үе хатуурч хатангиршихи, түнхний мултрал үүсгэдэг хэлбэр алдагдлын гажгийг тайлбарлаж, өдөр тутмын асаргаагаар эдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай заах.

(3) Бодитоор заах: "Шинээр сургах зүйл", "Хатангиршил, хэлбэр алдагдлаас урьдчилан сэргийлэх арга"-ыг эцэг эхчүүд өөрсдөө гэртээ хэрэгжүүлж чаддаг болоход зориулан зааж, сургуулилалт хийлгэх.

(4) Ганцаарчилсан зөвлөгөө: Урьдчилан төлөвлөсөн "Ганцаарчилсан зөвлөгөө өгөх" цагаар, дасгал хөдөлгөөн хийх явцад хүүхэд ямар байдалтай байгааг, эцэг эхчүүд гэртээ дасгал хөдөлгөөн хэрхэн хийлгэж байгааг ажиглан мэдэж, нэмэлт дасгал хөдөлгөөний зааварчилгаа өгөх, хүүхдийн хооллолт, асаргааны

талаар тулгарч буй бэрхшээлд зөвлөгөө өгөх зэргээр Монголд очих бүртээ эцэг эхчүүдтэй тулж ажиллах.

(5) Хүүхдийн асаргаа (тэврэх, живх солих, хувцаслах, хооллох зэрэг)-ны арга барилыг тухайн хүүхдийн онцлогт тохируулан гэрийн нөхцөлд хэрхэн хийж хэвшүүлэх талаар заах. Өдөр тутмын асаргааны эдгээр энгийн үйлдлүүдээр дамжуулан хөдөлгөөн заслын дасгал хийж болдог гэдгийг ойлгуулах.

Хүүхдийн хөдөлгөөний хөгжилд нөлөөлж, нааштай үр дүн гарч байгааг эцэг эхчүүд биеэр мэдэрснээр тэдний хандлага өөрчлөгдөж “гэрийн нөхцөлд хөдөлгөөн засал хийж болдог” гэсэн итгэл үнэмшил төрнө.

ГАНЦААРЧИЛСАН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЖИШЭЭ

Аутизм, спастик хэлбэр хавсарсан тархины саажилттай хүүхэд, 2 нас 11 сартай

(1) Эцэг эхтэй хийсэн ярилцлага

Эцэг эхийн хүсэлт: Өөрөө зогсож, алхдаг болох. Бичиг үсэгт сургах.

Зөвлөмж: Эцэг эх нь хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийн бодит байдлыг хүлээн зөвшөөрч, ойлголттой болсон байв. Хүүхдээдээ туслах мэрийлттэй бөгөөд аав нь зогсоход туслах хэрэгслийг гар аргаар хийснээ авч иржээ. Эхлээд “Юмнаас түшиж зогсдог болох” зорилго тавьж, гэрийн нөхцөлд ээж аав нь тусалж хийж хэвшүүлэх дасгал хөдөлгөөнүүдийн талаар тайлбарлав.

(2) Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, бие бялдрын өсөлт хөгжлийг үнэлэх

1/ ***Хүүхдэд тулгарч буй бие махбодын бэрхшээлийн тухай*****:** Булчингийн чангарах рефлекс (ATNR)-тэй тул толгой болон их бие тэнцвэргүй, ганцаараа суухад хүндрэлтэй. Баруун гар нугарсан байдалтай, сайн тэнийхгүй, булчин хэт чангаралтай, хөдөлгөөнөө хянаж чадахгүй учраас тоглоом атгаж барих, хооллоход хүндрэлтэй.

2/ ***Хүүхдийн өөрөө чадаж байгаа зүйлс*****:** Өнхрөх, элгээрээ мөлхөх, түшлэгтэй сандалд суугаад тоглох, суганаас нь тулбал өлмий дээрээ биеийн жингээ аваад зогсох.

3/ Цаашид хөдөлгөөний хөгжлийг дэмжих бэлтгэл: Түрүүлгээ буюу гэдсээрээ хэвтээд гарын шуугаар тулж, толгойгоо өндийлгөн эгц урагш харсан байрлалд хэсэг байлгах: Биеийн баруун зүүн хэсэг тэгш хэмтэйгээр түрүүлгээ харсан байрлалд байх нь толгой, их бие, дөрвөн мөчинд биеийн жингээ төвлөрүүлэх чадварыг хөгжүүлдэг. Энэ нь сууж сурахын бэлтгэл болно.

4/ Хоёрдогч эмгэг: Түшиж зогсоох үед өлмийдөж, гадагш гишгэлттэй зогсож байна. Зүүн гараараа тоглоом барьж тоглохдоо баруун гар нь мурийж чангардаг. Зогсохдоо өлмийдөж, гадагш гишгэж зогсож байгаа бол булчин хатангирших, хэлбэр нь алдагдахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Баруун дээд мөч (мөр, тохой, бугуй) хатангиршихаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.

(3) “Гэрээр хийх дасгал хөдөлгөөний хөтөлбөр” боловсруулж, хийх аргачлалын зөвлөмж хэрэгжүүлсэн.

Гэрээр хийх дасгалын жишээ:

1/ Ахилын шөрмөсний болон гуяны арын (2 толгойт) булчингийн сунгалт, шагайн үений дасгал

2/ Түрүүлгээ харж хэвтүүлэх: Гарын шуугаар тулж, толгойгоо өргөсөн байрлалд зурагт ном бариулж тоглуулах, эсвэл уншиж өгөх. Аажмаар хоёр тохойг сунган түрүүлгээ харж хэвтэхэд бэлтгэнэ.

3/ Тохиромжтой байрлалаар суулгах: Хүүхдийг нуруунаас нь түшиж эгц суулгаад хоёр гараа суган доогуур нь оруулж тэвэрнэ. Урд нь тоглоом өрж тавина. Хоёр гараараа зэрэг барьж тоглодог төрөл бүрийн тоглоом байвал зүгээр.

Нэмэлт зөвлөмж: Толгой цэх байрлалд түрүүлгээ харуулж хэвтүүлэх юм уу суулгаж тоглуулснаар биеийн тэнцвэрээ алдахгүй. Тоглоомоо харж, гараар хүрч, барьж авах зэргээр олон хөдөлгөөн оролцуулан тоглох нөхцөлийг бүрдүүлж өгвөл хүүхдийн танин мэдэхүйн боломж нэмэгдэнэ. Энэ нь мөн биеийн баруун дээд доод мөчинд үүсэх эрсдэлтэй хатангиршлаас урьдчилан сэргийлнэ.

(4) Дасгал хөдөлгөөн, асаргааг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн нь

2017 оны 6 сараас 2019 оны 4 сар хүртэлх хугацаанд нийт 6 удаа уулзан ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

Толгойгоо даах, биеийн тэнцвэрээ хадгалах чадварууд бага багаар сайжирсан зэрэг үр дүн ажиглагдсан ба гэртээ нэмэлтээр хийх шинэ дасгалуудыг зааж өгсөн. Түрүүлгээ харсан байрлалаас мөлхөх, суугаа байрлалд шилжиж чаддаг болсон.

(5) Гэрээр хийх дасгал хөдөлгөөний хөтөлбөрөөс гадна асаргаа (тэврэх, живх солих, хувцаслах, хооллох гэх мэт)-ны арга барилыг заасан. “Тархины саажилттай хүүхдийн асаргаа - Биеийн байрлал, хөдөлгөөн”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хооллолт” гарын авлагыг өгч, өдөр тутмын амьдралд хүүхдийг тохиромжтой байрлалаар тоглуулах, зогсоох, суулгах, хооллох тухай зөвлөмж зааварчилгаа өгсөн.

(6) Удирдамжийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 жил 2 сарын дараа 4 нас 10 сартайдаа ганцаараа сууж чаддаг болсон. Сандал дээр тэнцвэртэй сууж чаддаг болсноор дараагийн шатны дасгалууд буюу зогсох, алхахад чиглэсэн дасгал хийх бэлтгэл хангагдсан. Ганцаараа тэнцвэртэй суугаад тоглож бүрэн чаддаг болтол нь дасгалжуулалтыг тасралтгүй хийх шаардлагатай. Юм түшээд ганцаараа зогсдог болохын тулд дөрвөн хөллөх, өвдөг дээрээ зогсох, өгзгөө өргөж дөрвөн хөллөх дасгалыг өдөр тутамдаа хийх хэрэгтэй гэдгийг ээж аав хоёр нь маш сайн ойлгож, хэрэгжүүлсэн. Анх төсөлд оролцож эхлэх үедээ ээж аав нь “Хүүхэд маань хурдан ганцаараа зогсоод алхаж сураасай” гэцгээж байлаа. Хөлийн ул нь газарт бүрэн хүрдэггүй байсан ч сунгалтын дасгал хийсний дүнд чаддаг болсон, мөн толгойгоо даадаг болсон зэрэг бодит үр дүнг харсан тул урамшин, гэртээ ч уйгагүй дасгал хийлгэх болж, хүүхдээ хэрхэн өсгөж хөгжүүлэх талаар улам ихийг сурах эрмэлзэлтэй болсон. Түүнчлэн бусад эцэг эхэд өөрсдийн туршлагаасаа хуваалцаж, урам өгч байна.

(7) Эцэг эх нь гэртээ хүүхдэд тогтмол дасгал хөдөлгөөн хийлгэхийн ач тус:

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөлт хөгжилтийг дэмжих ганцаарчилсан хөтөлбөр”-г мэргэжлийн хөдөлгөөн засалч боловсруулж, хэрэгжүүлэх үед сувиллын цэцэрлэгт явдаг хүүхэд бол долоо хоногт 5 удаа, нэг удаадаа 20 минут дасгал хөдөлгөөн хийх боломжтой. Эсвэл сэргээн засах тусламж үйлчилгээний тасгаар үйлчлүүлнэ гэвэл долоо хоногт эсвэл сард нэг удаа 30 минутаар дасгал хөдөлгөөн хийнэ. Үүнээс үзэхэд дасгал хөдөлгөөнд зарцуулах цаг хэт бага байна. Манай төслийн багийнхан ч Монголд очих давтамж хязгаартай. Гэтэл бага насанд хүүхдийн бие бялдар, сэтгэлзүй аль аль нь өдөр өдрөөр өсөж хөгжиж байдаг. Тийм учраас дасгал хөдөлгөөний хөтөлбөрийн дагуу хүүхдэд хөдөлгөөн засал хийх тусам үр дүн гарах тул хүүхдээ гэртээ асрах явцдаа дасгал хөдөлгөөн хийлгэх нь чухал юм. Энэ нь хүүхдийн бие махбодын хөгжилд хэрэгтэй гэдгийг бодит жишээ бидэнд бататган харуулсан.

"НИНЖИН-ӨВСНИЙ ҮНДЭС ТӨСЛИЙН ӨДӨР"-ИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА

Бид энэхүү төслөөр “Гэгээлэн”, “Сайн найз” төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэмжлэг, хөдөлгөөн заслыг
1) Ганцаарчилсан зөвлөгөө
2) Групп дасгал-тоглоомын цаг (ээж аав нар хүүхэдтэйгээ хамтдаа дасгал хөдөлгөөн хийж, тоглох) гэсэн хоёр хэлбэрээр явуулж ирсэн. **"НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр"** бол Групп дасгалын цаг юм.

Ганцаарчилсан зөвлөгөө

Групп дасгал-Бобасын 12 дасгалын цаг

"НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр" бий болох хүртэл:

ЭХНИЙ ШАТ: Төслийн хөдөлгөөн засалч Монголд ирсэн үедээ Групп дасгал-тоглоомын цагийг 2017 оны 3 сар, 6 сар, 9 сард 3 удаа зохион байгуулсан.

Групп дасгал-тоглоомын цагийн агуулга: “Бобасын 12 дасгал + хөгжөөнт тоглоом”. Хүүхдүүдийг хөдөлгөөний чадвараар нь хоёр баг болгоно.

“Бобасын аргад үндэслэн боловсруулсан 12 төрлийн дасгал”-ыг нэг нэгээр нь нямбай хийснээр хүүхэд толгойгоо дааж, түрүүлгээ харж хэвтэж, биеэ суллан тайвширч амьсгалахад хялбар болж байв. Дасгалыг давтамжтай хийх явцад эцэг эхчүүд хийх арга барил, онцлогийг ойлгож авсан.
Гэртээ хүүхэдтэйгээ тэр бүр тоглоод байдаггүй ээж аав нар ч энэ өдрүүдэд хүүхэдтэйгээ хамт дуу дуулж, даавуугаар хийсэн дүүжин савлуур дээр хүүхдээ хэвтүүлээд савлуулж хөдөлгөх, бөмбөг дамжуулах зэргээр тоглосон. Тоглоомоор дамжуулан хөдөлгөөн засал хийх боломжтой гэдгийг эцэг эхчүүдэд ойлгуулсан.

Хөгжөөнт тоглоомын жишээ

Айзам хэмнэлт бүжиг (Bon bon dance): Янз бүрийн өнгөтэй цагариг толгой дээрээ тавьж унагахгүйгээр бэлхүүсээ баруун зүүн тал руу ээлжлэн хөдөлгөж бүжиглэнэ. Энэ нь толгойг эгц байрлалд байлгаж биеийн жинг баруун зүүн тийш тэнцвэртэйгээр хөдөлгөх чадварыг дээшлүүлнэ.

Даавуун савлуур: Хүүхдийг бүтээлгэн дээр хэвтүүлээд ээж аав, багш нар нь хоёр талаас нь бариад дуу дуулангаа зөөлөн савлуулж хөдөлгөнө. Ингэснээр тэнцвэр, хөдөлгөөний мэдрэмж өдөөгдөж (алгуурхан, хэмнэлттэй савлуулах) таатай сэтгэгдэл төрүүлж, бусад мэдрэмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болдог.

Бөмбөг дамжуулж тоглох

Даавуун савлуур

2017 оны 9 сард 4 дэх удаагаа Монголд ирэхдээ хоёр төвийн эцэг эхчүүдэд тусгайлан зориулж арга хэмжээ зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээгээр “НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-ийг ямар агуулгатай байх талаар танилцуулж, эцэг эхчүүдэд ойлголт өгсөн.

"ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ"-ийн утга учир:

Эцэг эхчүүд ганцаарчилсан зөвлөгөөний үеэр заалгасан дасгал хөдөлгөөн, зөвлөмжийг гэртээ хэрэгжүүлж, төв дээр ирсэн үедээ бусад хүүхэд, ээж аав нартай хамт дасгал хийж, зурагт ном уншиж өгөх, ярилцах, мэдээлэл солилцох зэргээр цагийг үр бүтээлтэй өнгөрүүлдэг. Хөгжлийн дэмжлэгийг гэрт, мөн төв дээр дадал болгосноор ач холбогдлыг нь аяндаа ойлгох болсон.

ХОЁР ДАХЬ ШАТ: “НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр” тогтмол үйл ажиллагаа болов.

2017 оны 10 сараас эхлэн хоёр төв дээр долоо хоног бүрийн бямба гаригт хүүхэд, ээж аав нар цуглаж **“НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-т** хамрагдах болсон.

“НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-ийн үйл ажиллагааг төвийн тэргүүн, туслах ажилтны хамт зохион байгуулдаг. Төслийн багийн хоёр орчуулагч энэхүү үйл ажиллагаанд сард нэг удаа оролцдог бөгөөд сувилагч мэргэжилтэй орчуулагч нь хөдөлгөөн засалд тусалдаг. Хөдөлгөөн дасгалын багт 10 гэр бүл, суралцахуйн багт 10 хүүхэд хамрагдсан.

НИНЖИН-ӨВСНИЙ ҮНДЭС ӨДРИЙН АГУУЛГА

10:30 Үйл ажиллагаа эхэлнэ.
Ирцийн бүртгэлийн хүснэгтэд стикер наалт наана.
10:45 Сунгалтын дасгал, хөдөлгөөн хийнэ.
11:15 Зурагт ном уншиж өгнө. Камишибай уншина.
11:30 Хөдөлгөөнт тоглоом (Даавуун савлуур, шидэт хивс гэх мэт)-оос сонгож тоглоно. Энэ цагт суралцахуйн баг өөр өрөөнд тооны хичээл зэргийг хийнэ.
12:00 Үдийн хоолны цаг
13:00 Бүгд хөдөлгөөнт тоглоом (үдээс хойш ирдэг хүүхдүүдийг оролцуулаад) тоглодог.
Хөдөлгөөнт тоглоомын жишээ: Хийлсэн бөмбөлгөөр тоглох, айзамт бүжиг (bonbon dance) хийх, өнгөт цагариг дотор гишгэж явах, тэнцвэрт бөмбөгөөр тоглох
14:00 Эцэг эхчүүдийн цаг: Тоглоомын хэрэгсэл зэргийг хамтдаа хийдэг.
Тухайлбал: Өнгөт цагариг, хуванцар саваар хөгжмийн зэмсэг, сүүний саваар шоо. Хөдөлгөөн дэмжигч хэрэгсэл: сүүний саваар сандал, ширээ, Т хэлбэрийн сандал хийх, даавуу, хөөсөнцөр ашиглан хүзүүвч чиг хийх
14:30 Дуу дуулж өдрийн хаалт хийнэ.

“НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-ийг 2017 оны 10 сараас зуны амралт (7, 8-р сар)-аас бусад үед долоо хоног бүр тогтмол зохион байгуулахыг зорьж ирсэн. Хөдөлгөөн засалч 2-оос 3 сард нэг удаа дасгал хөдөлгөөний шинэ хөтөлбөрийг төвүүд рүү мэйлээр явуулж байв. Заримдаа skype ашиглан төвтэй холбогдож эцэг эхчүүдийн асуултад хариулдаг байв. 2018 оны 10 сараас 2019 оны 5 сар хүртэлх хугацаанд Монголын бие бялдар хөдөлгөөн заслын холбооны дэмжлэгээр хөдөлгөөн заслын ангийн оюутнууд (8 хүн) сайн дурын ажил хийн тус өдөрт оролцох болсон.

ГУРАВ ДАХЬ ШАТ: Төсөл дууссан ч “НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-ийг хоёр төв дор бүрнээ үргэлжлүүлэн хийсээр байна.

2019 оны 8 сард төсөл дууссан. 2019 оны 9 сараас хоёр төв “НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөр”-ийг үргэлжлүүлэн зохион байгуулж байхаар шийдсэн бөгөөд хөдөлгөөн заслын мэргэжилтэн шаардлагатай гэсэн саналыг бидэнд тавьж байв. Энэ хүсэлтийг харгалзан НИНЖИН ТББ үргэлжлүүлэн 1 жилийн хугацаатай дэмжлэг үзүүлэх болсон.

Хөдөлгөөн заслын мэргэжилтэн (хөдөлгөөн заслын сургалтын оролцогч, төв дээр дадлага хийсэн) 1 хүн, сувилагч (өмнө нь төслийн орчуулагчаар ажиллаж байсан)-ийн хамт НИНЖИН-Өвсний үндэс төслийн өдөрт очиж ажилласан.

Хөдөлгөөн заслын холбооноос санал болгосон хөдөлгөөн засалч 1 хүн, анагаахын сургуулийн хөдөлгөөн заслын тэнхимийн оюутан-сайн дурын 8 хүн төвүүдэд очиж ажилласан.

2019 оны 10 сараас сард 1 удаа “Өвсний үндэс төслийн өдөр”-өөр хоёр төвд тогтмол 7 хүн (хөдөлгөөн заслын мэргэжилтэн 3 хүн, оюутан-сайн дурынхан 5 хүн) очиж дэмжлэг үзүүлж байсан боловч 2020 оны 2 сараас 2021 оныг дуустал корона вирусийн халдвар тархахаас сэргийлж төвүүдийн үйл ажиллагааг хааснаар энэхүү үйл ажиллагаа зогсонги байдалд орсон юм.

Шааран волейбол



Даавуун үүл

ХҮҮХДИЙНХЭЭ ЖИЖИГ АМЖИЛТ БҮРИЙГ АНХААРЧ, УРАМ ӨГӨӨРЭЙ

НОГҮЧИ ЁОКО ***(Тусгай сургуулийн багш)***

- Хичээл хийх гоё уу?

- Мэдээж шүү дээ.

- Яагаад ийм ойлгомжтой юм асуудаг юм бэ..

Төслийн багийн гишүүн Ногүчи багш насаараа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилласан хүн юм. Тэрээр өдгөө тэтгэвэртээ гарсан ч Токио хотын дунд сургуульд хичээлээ гүйцэхэд хүндрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж, эцэг эхчүүдэд нь зөвлөгөө өгдөг.

Ногүчи багш уг төсөлд хоёр төвийн хүүхдүүдэд тоо, өнгө, дүрс зэрэг математикийн анхан шатны ухагдахуунуудыг заах зорилготойгоор оролцсон. Тэрээр Японоос сургалтын хэрэглэгдэхүүн, тооны дасгал ажлын материалууд авчирч, мөн гар доорх материалаар хийсэн сургалтын хэрэглэгдэхүүн ч ашигладаг байв.

Хүүхдийг хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомыг заавал өндөр үнээр худалдан авах бус гар доорх материалаар ч маш өгөөжтэй зүйлс хийж болдгийг манай төслийн Ногүчи багш, Наоко багш нараас хоёр төвийн эцэг эхчүүд болон сургалтад хамрагдсан эцэг эх, багш нар суралцсан билээ.

Ногүчи багш хүүхэд бүрийг жинхэнэ мэргэжилтэн багшийн нүдээр маш анхааралтай ажиглаж, хүүхдээ хэрхэн хөгжүүлэх, сургуульд хамруулах, боловсролд нь хэрхэн анхаарах талаар эцэг эхчүүдтэй чөлөөтэй ярилцаж, өөрийн туршлага дээрээ үндэслэн зөвлөгөө өгч байв.

НОГҮЧИ БАГШИЙН ЗӨВЛӨГӨӨ

"Хүүхдийг энгийн сургуульд сургах тохиолдолд хүүхдийнхээ хүслийг ч мөн хүндлэх хэрэгтэй. Сургууль, анги даасан багштай нь уулзан ямар төрлийн хичээл заах, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулсан эсэхийг заавал ярилцах хэрэгтэй. Сургууль, багш, эцэг эх нэг баг болж байж хүүхдийг сургуульд хамруулдаг.

Хүүхдийн хөгжлийг гэрийн орчинд өдөр тутам дэмжих боломжтой. Хүүхэд заавал хичээлийн ширээний ард сууж байж л суралцдаг юм биш. Гэртээ байх хугацаандаа ч хөгжих боломжтой. Тиймээс гэртээ байнга “Тэр ямар өнгө вэ”, “Энэ юу вэ, ямар хэлбэртэй байна” гэх мэтээр хүүхэдтэйгээ ярилцах хэрэгтэй. Хүүхдийнхээ жижиг гэлтгүй амжилт бүрийг анхаарч, урам зориг өгч байгаарай."

САЙН НАЙЗ төвд

Гэрт болон сургуульд тоог ямар дарааллаар заах вэ

НОГҮЧИ ЁОКО *(Тусгай сургуулийн багш)*

1. Ижил зүйлсийг сонгох (Энэ зургаас алимуудыг сонгоорой)



2. Өнгө ялгах. Ижилхэн хэлбэр дүрстэй хэрэглэгдэхүүн ашиглаарай.

3. Өнгөний нэрийг сурах

4. ○ △ □ Дугуй, гурвалжин, дөрвөлжнийг ялгаж сурах

5. ○○ △△ □□ Дээрх дүрсүүдийг ашиглан том жижгийн ялгааг заах

6. —— – Урт, богиныг ойлгох. Урт, богино гэх үгсийг мэддэг болох

7. 1-ээс 5 хүртэлх тоог ижил тооны зүйлстэй харгалзуулах

8. Өнгө заахад ашигласан кубээр 5 дотор нэмэх үйлдэл хийх.

1 + 1 = 2

9. 5 дотор хасах үйлдэл хийх

3 - 2 = 1

10. 10 хүртэлх тоог ижил тооны зүйлстэй харгалзуулах
11. 10 дотор нэмэх
12. 10 дотор хасах
13. 20 дотор нэмэх
14. 20 дотор хасах
15. 20 доторх тоо оролцсон нэмэх (аравт хэтрүүлэн нэмэх)
16. 20 доторх тоо оролцсон хасах (аравт хэтрүүлэн хасах)
17. 2 оронтой тооны нэмэх
18. 2 оронтой тооны хасах
19. 2 оронтой тооны нэмэх (орон хэтрүүлэн нэмэх)
20. 2 оронтой тооны хасах (орон хэтрүүлэн хасах)
21. 3 оронтой тооны нэмэх
22. 3 оронтой тооны хасах
23. Хүрд цээжлэх
24. 2 оронтой тоог 1 оронтой тоогоор үржих
25. 2 оронтой тоог 2 оронтой тоогоор үржих

ЦӨӨН ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ СУРГАЛТ, ХҮҮХЭД ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

МАЦҮМОТО НАОКО ***(Цэцэрлэгийн багш)***

Би 2018 оны 9 сард уг төслийн ажлаар Монголд очсон. Гол зорилго нь заасны дагуу дагаж хийх сургалтын идэвхгүй хэлбэрээс хүүхдийн идэвх санаачилгыг хөгжүүлэх хэлбэрийг чухалчилсан хөтөлбөрийг хоёр төв дээр туршиж үзэх байв. Тодруулбал, хүүхэд, эцэг эх хамтдаа тоглох арга хэлбэрийг голлосон цөөн хүний бүрэлдэхүүнтэй хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Хүүхдийн баримжаалж чадахуйц цөөн тооны хүнтэй групп үүсгэн тоглуулбал хүүхэд аюулгүй, тайван байдлыг мэдэрч, үе тэнгийнхэнтэйгээ харилцах, зарим үед санаснаар нь болохгүй тохиолдолд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх вэ гэдгийг сурдаг.

Мөн тоглоомоор дамжуулан “маш гоё, хөгжилтэй”, “гунигтай”, “гомдолтой” гэх мэт сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сэтгэл хөдлөлөө хянах, зөвхөн өөрийгөө гэх биш бусдыг гэсэн сэтгэл, хүнтэй харилцах талаар мэдэж авах боломж бүрддэг. Нэрийг нь дараалаар хэлүүлэх, цөөн хүүхэдтэй баг дотроо ээлж дараалаар стикер наалт авах, амттан авах гэх зэргээр “өөрийн ээлж иртэл хүлээх” дадал суулгах нь хүүхдэд “аливаа юм үргэлж өөрийн хүссэний дагуу байхгүй” гэдгийг ойлгуулдаг.

САЙН НАЙЗ төв дээр

Хүүхдийн сэтгэлзүйг төлөвшүүлэхэд хөгжүүлэх арга барил чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг ойлгосон.

Ганцаараа бие засаж чадсан, хувцсаа өмсөж чадсан, хоолоо ганцаараа идсэн гэх мэт өдөр тутмын амьдралд “хийж чадсан” гэдэг мэдрэмж төрүүлэх зүйл олон байдаг. Гэвч “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд учраас....” гээд юм болгоныг өмнөөс нь хийж өгөх, эсвэл онцгойлон анхаарах хандлага хэвшсэн өнөөгийн нөхцөлд тэдгээр хүүхдүүдтэй ажиллаж байхад “өөртөө итгэлгүй” байдал их анзаарагддаг. Тийм ч учраас хөгжүүлэх хөтөлбөрийн агуулгад өдөр тутмын амьдралд шаардлагатай хөтөлбөрийг багтааж, өдөр тутмын амьдралын хэв маяг, тоглоомоор дамжуулж “хийж чадсан” үйлдлээр нь өөртөө итгэх итгэл бий болгох нь өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэхэд ч түлхэц болно гэдгийг эцэг эх, гэр бүлийн хүмүүст хэлмээр байна. Үе үе үйлдлээ анзаарч анхаарч байхгүй бол өөрийн мэдэлгүй “өмнүүр нь орж хийж өгөх амьдралын хэв маяг” хэвших талтай. Бүгдийг нь биш юм гэхэд юуг өөрөөр нь хийлгэвэл хүүхдэд “чадлаа” гэсэн мэдрэмж төрөх бол, зөвхөн энэ хэсгийг л хийх гээд оролдоод үз дээ гэвэл яах бол, гэх зэргээр томчууд өөрсдөө оролдлого, санаачилгатай байх чухал. Уйгагүй зүтгэл шаардах ч хүүхдийн өөрөө чадах зүйл нэг нэгээр нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

ЭЦЭГ ЭХТЭЙГЭЭ ХАМТ ТОГЛОХ ХӨТӨЛБӨР

Хүүхэд өөрөө идэвхтэйгээр биеэ хөдөлгөх, үеийн хүүхдүүдтэй хөгжилдөж байгаа байдлыг эцэг эхчүүд хамтдаа мэдрэх нь чухал ач холбогдолтой байдаг. Хүүхэд ба багш гэсэн ганцаарчилсан харилцааг биш ээж аавууд нь ч оролцож хамтдаа тоглох арга хэлбэрийг түлхүү ашигласан.

Гар, биеэ оролцуулсан хөдөлгөөнт тоглоомоос гадна ээж аавууд хүүхэдтэйгээ хамт бүтээл урлах цагийг гаргаж, гэртээ байхдаа ч хүүхэдтэйгээ хамт тоглох тоглоом, хөдөлгөөн заслын аргыг заасан. Ийнхүү бие биедээ хүрэлцэж мэдрэх мэдрэмж нь эцэг эх, хүүхэд хоорондын хайрын харилцааг бэхжүүлэхэд нөлөөлдөг.

Эцэг эхчүүдийн зүгээс “Өмнө нь хөдөлгөөн засал хийхийг хүнд ачаа мэтээр хүлээж авдаг байв. Хүүхэд хөгжүүлэх туршилтын арга хэмжээнд оролцсоноор хүүхэд өөрөө санаачилгатай болж, хамт тоглоё гэж хүсдэг болсон. Өдөр тутмын асаргаа сувилгаанаас гадна хүүхэдтэйгээ харилцах хамт өнгөрүүлэх цаг нэмэгдсэн. Урьд нь олж харж байгаагүй царайны хувирал, төсөөлж байснаас ч илүү баяр хөөртэй байгааг нь хараад баярлаж байна” гэх зэргээр сэтгэгдлээ хуваалцаж байв.

Эцэг эх-хүүхэд баг болж тоглох явцад хүүхэд төдийгүй эцэг эхчүүд ч өөр хоорондоо танилцах боломж бүрдэж, сэтгэл зовоосон асуудлаа хуваалцах орчин бүрдсэнд энэ арга хэмжээний нэг ач холбогдол оршиж буй юм.

Төвүүд дээр арга хэмжээ зохион байгуулахдаа зөвхөн тоглоом зааж, хамтдаа хийгээд дуусгах биш эцэг эхчүүдийг хэрхэн татан оролцуулах, ээж аав-хүүхэд бүгд сэтгэлээ нээж харилцах орчныг хэрхэн бүрдүүлэх вэ гэдгийг төвийн ахлагч нартай хамтран бодож, хийж ирсэн.

Хүүхдүүд, эцэг эхчүүд төв дээр ирээд “зорилго нэгтэй, ижилхэн зовлон бэрхшээлтэй” найз нөхөдтэй болсон нь хичээл зүтгэлээ алдахгүй байх эрч хүчийг төрүүлж, амьдралын амтыг мэдрэх хүч чадлыг өгдөг болов уу гэж бодож байна.

Миний бие хөдөлгөөн заслаар дамжуулан Монголтой холбогдсон билээ. Хүүхэд, томчууд цуглаад хамт байхдаа сэтгэл тайвшрах орчныг бүрдүүлж чадаж байвал түүний арга зам нь ямар ч байж болно гэж надад санагдсан. Миний хувьд “Хөгжүүлэх хөтөлбөр” гэдэг аргаар үүнд оролцсон. Монголд цаашдаа ч ийм төв, орчин олноор бий болоосой гэж чин сэтгэлээсээ хүсэж байна.

Эцэг эхчүүдийн сургалт

Гарын доорх материалаар тоглоом хийцгээе

МАЦҮМОТО НАОКО *(Цэцэрлэгийн багш)*

Харж, хүрч, хөдөлгөж тоглох машин зам

Энэхүү тоглоом нь хүүхдийн дээд их бие, гарын дасгал болох бөгөөд гар, нүд хоёроо зэрэг ажиллуулах чадварыг дэмжинэ.

Бэлдэх зүйлс:

Соруул, бүдүүн утас, эсвэл үдээс мэтийн уяа 90 см, зургийн дэвтрийнх шиг зузаан цаас 2 х 2 см хэмжээтэй 3 ширхэг, өнгийн харандаа, скоч





Хийх арга:

1. Жижиглэн хайчилж бэлдсэн цааснууд дээрээ машин, автобус, зогсоолын тэмдэг зэргийг зурж хэлбэр гарган хайчилна.
2. Соруулыг 1см урттай хайчлаад цааснуудын ард скочоор нааж тогтооно.
3. Соруулд уяаг сүвлэнэ.

Хэрхэн тоглох вэ

Аав ээж нь утсыг хоёр талаас нь татаж барина. Хүүхэд машин, автобусыг хөдөлгөж тоглоно. Ээж аав ч хамтдаа хөгжилдөн тоглож “Автобус ирлээ”, “Машин хөдөллөө” гэх мэтээр сайн ярих хэрэгтэй. Хүүхдээ сайн түшиж, мөн машиныг хөдөлгөхөд нь тусалж болно.

Машинаас өөр зүйлс, жишээлбэл амьтад зураад ар араас нь гүйлгэж хөөцөлдүүлж болно. Тоглох аргыг хүүхдэд тохируулан янз бүрээр өөрчилж болно.

Шаржигнуур тоглоом

Бэлдэх зүйлс:

Ундааны хоосон сав, хоосон аяга, нойлын цаасны гол, скоч, саванд хийх зүйлс (жижиглэж хуваасан соруул, жижиг товч зэрэг)

Эд зүйлс бүр өөр өөрийн аялгууг гаргана:

– Чимэглэл

– Элс

– Соруул

– Самар

Хийх арга:

1. Ундааны хоосон сав, хоосон аяга, нойлын цаасны гол руу жижиглэж хуваасан соруул, жижиг товч зэргийг хийнэ.
2. Савыг таглаж, скочоор битүүлнэ. Нойлын цаасны хоёр талыг зузаан цаас зэргээр таглаж байгаад наана.

Хэрхэн тоглох вэ

Дуулахдаа эсвэл хөгжим сонсохдоо хэмнэлд нийцүүлэн сэгсэрч тоглоно. Сэгсрэх, атгах хөдөлгөөнийг сайжруулна. Өөрөө чимээ гаргах, найзуудтайгаа янз бүрийн чимээ гаргаж тоглохдоо хүүхэд маш дуртай байх болно.

ЗУРАГТ НОМ УНШИЖ ӨГӨХ

ҮМЭМУРА КИЁОРА ***(Хүүхдийн эмч)***

Хүүхдүүд зурагт номд их дуртай. Миний бие олон жилийн турш хүүхдийн эмчээр ажиллахдаа өөрийн эрхлэн ажиллуулдаг эмнэлгийн хүлээлгийн өрөөнд зурагт номууд байршуулж “НИНЖИН номын сан” гэж нэрлэн, ээж нарыг хүүхдээ ном уншиж өгөх орчныг бүрдүүлсэн. Түүнчлэн эмнэлгийн өргөтгөл болгож тохижуулсан хэл заслын өрөөнд хэл яриа, сонсголын сэргээн заслын мэргэжилтэн үзлэг зөвлөгөөнд ирсэн хүүхдэд заавал зурагт ном уншиж өгдөг. Тархины саажилттай хэвтэрт байдаг хүүд “Гүнжийн инээд” нэртэй зурагт номыг хэдэн зуун удаа уншиж өгсөн. “Ха ха ха” гэж олон дахин унших явцад сонсож байгаа, уншиж байгаа хэн хэн нь номоо дуурайн өөрийн мэдэлгүй инээж, цагийг баяр баясалтайгаар өнгөрүүлдэг.

Японд Иточү сангийн “Вайвай номын сан” системд хүсэлт гарган дижитал хэлбэрийн зурагт номыг компьютер, гар утсандаа татаж суулган унших боломжтой. Дэлгэцэн дээр зураг, өгүүлбэр гарч ирэхэд автоматаар үйл явдлыг ярьж өгдөг. Үсгийн хэмжээ, уншиж өгөх хурдыг өөрчлөх зэргээр хүссэнээрээ тохиргоо хийж болно. Хүүхэд дуртай номоо өөрийнхөө нөхцөлд тааруулан дахин дахин унших боломжтой юм.

Саяхан Монголд ЖАЙКА-ийн хэрэгжүүлдэг “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд монгол хэл дээр дижитал зурагт номуудыг бүтээсэн тул татаж авч гэртээ хэрэглэх боломжтой эсэхийг асууж тодруулаарай.

“Сайн найз”, “Гэгээлэн” төв дээр хүүхдүүдэд ном уншиж өгөх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд бид эхний удаад 100 ном, дараа нь шинэ жилийн баяр гэх мэт тэмдэглэлт баярын үеэр хэдэн арван ширхэг ном хандивласан. Төслийн орчуулагч сард нэг удаа хоёр төв дээр очих үедээ хүүхдүүдэд ном уншиж өгөх уншлагын цаг бий болгосон.

Зурагт ном ямар сонирхолтой болохыг төвийн хүүхдүүд, эцэг эхчүүд анзаарч мэдэрсний дараа ээж аав нь хүүхдээ, том хүүхдүүд нь багачууддаа өдөр тутамдаа ном уншиж өгдөг болсон. МУБИС-ийн сайн дурын оюутнууд ч “Сайн найз” төв дээр ирсэн үедээ хүүхдүүдэд зурагт ном уншиж өгдөг.

НОМ БОЛ ХООЛ ХҮНСТЭЙ АДИЛ АМЬДРАЛЫН НААД ЗАХЫН ХЭРЭГЦЭЭ. ХҮҮХДИЙГ НОМТОЙ ОЙР ӨСГӨХ ЁСТОЙ.

Учир нь,

1-рт, хүүхэд номоос мэдэхгүй зүйлээ сурч авдаг

2-рт, телевиз, гар утас зэрэгт донтохоос сэргийлдэг

3-рт, хэл ярианы хөгжилд тустай

4-рт, оюун ухааны ерөнхий хөгжил буюу сэтгэх хүрээ нь нэмэгддэг

5-рт, хүмүүжлийн ач холбогдолтой

6-рт, зөв зан чанарууд төлөвшинө

ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГИЙН ДЭВТЭР

ҮМЭМУРА КИЁОРА ***(Хүүхдийн эмч)***

Төсөлд хамрагдсан хүүхэд бүрд зориулан “НИНЖИН - Хөгжлийн дэмжлэгийн дэвтэр”-ийг эрхлэн хэвлэв. Төслийн багийн эмч хүүхдийн өсөлт, эрүүл мэндийн байдал, хөдөлгөөн засалч хөгжлийн дэмжлэг, хөдөлгөөн заслын зөвлөгөөний тэмдэглэл оруулсан.

Энэхүү дэвтэр нь эцэг эх, асран хамгаалагч, хөдөлгөөн засалч, багш, эмч зэрэг хүмүүст тухайн хүүхдийн мэдээллийг цэгцтэй өгөх зорилготой.



3

ТӨСЛӨӨС ЗӨХИӨН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, ЛЕКЦ

СУРГАЛТЫН АГУУЛГА БА ЗОРИЛГО

Хөдөлгөөн заслын мэргэжилтнийг чадавхжуулах сургалт: Хөгжлийн бэрхшээлийн шалтгааныг үнэлэн, тохирох хөдөлгөөн засал хийх аргазүйг заах

Өрхийн эмч, сувилагчид зориулсан сургалт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзлэг хийх тохиолдол олонтоо гардаг өрхийн эмч нарт мэргэжлийн мэдлэг олгох

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо (цаашид ХБХЭЭХ гэх)-ны ээж аав нарт зориулсан сургалт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулан хүүхэдтэй хэрхэн харилцах талаарх аргазүйг заах

1. ХӨДӨЛГӨӨН ЗАСЛЫН МЭРГЭЖИЛТНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ, ДАДЛАГА АЖИЛ

Хөдөлгөөн заслын мэргэжилтнийг чадавхжуулах 7 удаагийн цуврал сургалт зохион байгуулсан. Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн заслын мэргэжилтэн буюу хөдөлгөөн засалч, эмч, сувилагч, цэцэрлэг сургуулийн багш нар, эцэг эхчүүд сургалтад оролцсон. Тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн заслын тухай мэдлэг дадал, аргазүйн ойлголт өгсөн.

Дараах сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэн сургалтад оролцогчдод тараасан. Үүнд:
- “Тархины саажилттай хүүхдийн асаргаа: Биеийн байрлал, хөдөлгөөн” гарын авлага
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа: Хооллолт” гарын авлага
- “Бобасын аргад үндэслэн гаргасан 12 төрлийн дасгал”
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хооллолт” видео хичээл

Цуврал сургалт зохион байгуулах бүрд хөдөө орон нутгаас оролцогчид нэмэгдэж байв. Оролцогчид “демо-дадлага ажлаар эзэмшсэн хооллолт, асаргааны аргазүйг ажлын байран дээрээ нэвтрүүлж хэрэгжүүлэх болно” гэж олзуурхаж байсан.
7 удаагийн сургалтын сэдвүүдийг товч танилцуулъя. Үүнд:

1 дэх сургалт:
- Сунгалт, үе мөчний дасгал
- Бобасын аргад үндэслэн гаргасан 12 төрлийн дасгал

2 дахь сургалт:
- “Тархины саажилттай хүүхдийн асаргаа: Хөдөлгөөн, биеийн байрлал” гарын авлагыг ашиглах зөвлөмж
- Демо буюу бодит жишээн дээр тайлбарлах сургалт-дадлага ажил (2 хүүхдийн жишээгээр үзүүлэв)

3 дахь сургалт:
- Тархины саажилттай хүүхдийн хөлд үүсэх бэрхшээл, гэрийн нөхцөлд хийх хөдөлгөөн засал (демо)
- Ортопед-согог заслын эмчийн тархины саажилтын талаарх лекц

4 дэх сургалт:
- Тархины саажилттай хүүхдийг үнэлэх: Гэрийн нөхцөлд хийх хөдөлгөөн заслын хөтөлбөр гаргах арга
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа: Хооллолт” гарын авлагыг ашиглах зөвлөмж, хооллолтын демо-дадлага (2 хүүхдийн жишээгээр үзүүлэв)

5 дахь сургалт:
- Хүнд хэлбэрийн оюуны болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн хөдөлгөөн засал, хооллолт, асаргаа
- Хооллолтын демо-дадлага ажил (2 хүүхдийн жишээгээр үзүүлэв)

6 дахь сургалт:
- Атетоз хэлбэрийн тархины саажилттай хүүхдийн хөдөлгөөн заслын лекц
- Тэргэнцэр дээр зөв суулгах демо-дадлага ажил

7 дахь сургалт:
- Тархины саажилттай хүүхдийг өсгөхөд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч зэрэг мэргэжилтнүүдийн үүрэг
- Атетоз хэлбэрийн саажилттай хүүхдийг хувцаслах, тоглуулах, хооллох демо-дадлага ажил (2 хүүхдийн жишээгээр үзүүлэв)

2. ӨРХИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Өрхийн эмч, сувилагч нарт зориулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ, асаргааны талаар 5 удаагийн сургалт зохион байгуулсан. Мэдлэг мэдээлэл авах хүсэлтэй олон эцэг эх ч мөн оролцсон.

1 дэх сургалт:
- “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг ашиглах зөвлөмж (Хүүхдийн эмч)
- Тархины саажилттай хүүхдэд дагалдах байдлаар илэрдэг хооллох бэрхшээл, хооллолтын гарын авлага ашиглах зөвлөмж (Хөдөлгөөн засалч)

2 дахь сургалт:
- Бага насны хүүхдийн ортопед-согог ба тархины саажилттай хүүхдийн эмчилгээний талаарх үндсэн мэдлэг (Ортопед-согог заслын эмч)
- “Тархины саажилттай хүүхдийн асаргаа: Биеийн байрлал, хөдөлгөөн” гарын авлага (демо-дадлага ажил бүхий) болон хооллолтын гарын авлага (видео хичээл бүхий) ашиглах зөвлөмж (Хөдөлгөөн засалч)

3 дахь сургалт:
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн үзлэг, эмчилгээ-1 (Хүүхдийн эмч)
- Атетоз хэлбэрийн тархины саажилттай хүүхдэд гэрийн нөхцөлд хийх хөдөлгөөн заслын демо-дадлага ажил (Хөдөлгөөн засалч)

4 дэх сургалт:
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн үзлэг, эмчилгээ-2 (Хүүхдийн эмч)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах арга барил (Цэцэрлэгийн багш)
- Сургалтын оролцогчидтой хамтарсан воркшоп

5 дахь сургалт:
- Бага насны хүүхдийн ортопед-согог, тархины саажилттай хүүхдийн эмчилгээний талаарх үндсэн мэдлэг (Ортопед-согог заслын эмч)
- Хүнд хэлбэрийн оюуны болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ (Мэдрэлийн эмч)
- Биеийн байрлал, хөдөлгөөн болон хооллолтын гарын авлага, видео хичээл ашиглах зөвлөмж (Хөдөлгөөн засалч)

3. ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Төслийн хамтрагч байгууллага ХБХЭЭХ-ны эцэг эхчүүдэд зориулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрхэн өсгөх талаарх 5 удаагийн цуврал сургалтыг зохион байгуулсан.

1 дэх сургалт:
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг ба асаргаа (Хүүхдийн эмч)

2 дахь сургалт:
- Тархины саажилттай хүүхдийн тулгуур эрхтний эмчилгээ (Ортопед-согог заслын эмч)
- Гэрийн нөхцөлд хийх хөдөлгөөн засал (Хөдөлгөөн засалч)

3 дахь сургалт:
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга (Хүүхдийн эмч)
- Хөдөлгөөн заслын талаарх үндсэн ойлголт, арга барил (Хүүхдийн эмч)

4 дэх сургалт:
- Дауны хамшинжтэй хүүхдийн талаарх баримтат нэвтрүүлэг (Хүүхдийн эмч)
- Хөдөлгөөн засал хийх арга барилын тухай (Хөдөлгөөн засалч)

5 дахь сургалт:
- Төслийн багийн гишүүд (хүүхдийн эмч, сургууль, цэцэрлэгийн багш, хөдөлгөөн засалч) тус тусын мэргэжлийн үүднээс эцэг эхчүүдэд лекц орсон.

Төслөөс зохион байгуулсан сургалтуудын зарим тараах материалыг **Ninjin NPO НИНЖИН ТББ (https://www.facebook.com/ninjinnpo)** фэйсбүүк пэйж дээр байршуулсан болно.

- **Бага насны хүүхдийн ортопед-согогийн тухай**
  Широ Рёожи (Ортопед-согог заслын эмч)

- **Тархины саажилттай хүүхдийн оношилгоо, эмчилгээ**
  Широ Рёожи (Ортопед-согог заслын эмч)

- **Хүнд хэлбэрийн оюуны болон биеийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээ**
  Огава Кацүхико (Дотрын эмч)

- **Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга**
  Үмэмүра Киёора (Хүүхдийн эмч)

- **“Тархины саажилттай хүүхдийн асаргаа: Биеийн байрлал, хөдөлгөөн”**
  Мороиши Марико (Хөдөлгөөн засалч)

- **“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа: Хооллолт”**
  Мороиши Марико (Хөдөлгөөн засалч)



ТӨГСГӨЛД НЬ

НИНЖИН ТББ 2014 онд Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нөхцөл байдлын талаар судалгаа хийсэн юм. Уг судалгааны дүн ч нөлөөлж, бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, нийгмээс тусгаарлагдсан гэр бүлүүдэд бага ч болов дэм болохоор энэхүү төслийг санаачлан, ЖАЙКА-ийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн билээ.

Энэ гурван төслийн гишүүн бүр хичээж, багагүй саад бэрхшээлтэй тулгарч байсан ч хоёр төвийн хүүхдүүдийн баяр хөөр, инээмсэглэлийг харж эрч хүч аван урагшилсаар ирсэн юм.

Хоёр төвийн үүсгэн байгуулагч нар улсаас дорвитой дэмжлэг авах боломж хомс нөхцөлд өөрсдийн өрхийн төсвөөс хүртэл төвийн үйл ажиллагаанд зориулсаар, бидэнтэй хамт өдийг хүртэл хичээж ирсэн. Биднээс гадна төвийг дэмждэг олон хүн, байгууллагын ачаар ийнхүү хоёр төвийн гал бөхөлгүй ассан хэвээр байна. Энэхүү тайлан тэмдэглэл хоёр төв рүү замчлах хөтөч болж, тэдний гал цаашид ч ассан хэвээр байж, төвийн үйл ажиллагаа улам цэцэглэж, Монгол даяар жишиг-загвар болоосой хэмээн хүсэж байна.

Энэ төсөл олон эрхэм хүний чин сэтгэлийн дэмжлэгээр хэрэгжиж ирсэн. Ялангуяа САЙН НАЙЗ төвийн тэргүүн Ж.Алтантүлхүүр, ГЭГЭЭЛЭН төвийн тэргүүн Ц.Уянга нарын оролцоо, хүчин чармайлтгүйгээр өдийг хүрэхгүй байлаа. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн С.Сэлэнгэ, төслийн орчуулагчаар ажилласан Ё.Оюунгэрэл, Д.Чимгээ нарын тус дэмжлэгт бид ихэд талархаж байна. Төсөлтэй холбогдсон, дэмжсэн бүх хүнд маш их баярлалаа. Монголд хэзээ нэг өдөр инээмсэглэл дүүрэн уулзах мөрөөдлийг сэтгэлдээ мэдэж дахин тээгээд энэ төслөө төгсгөж байна.

Төслийн Санхүү хариуцсан гишүүн,
Сүзүки Шигэрү

2021 оны Гуравдугаар сар

ТӨСӨЛ ДУУССАНААС ХОЙШ

НИНЖИН төрийн бус байгууллагаас ЖАЙКА-ийн Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд гурван жил хэрэгжүүлсэн төсөл 2019 оны 8-р сард дууссан боловч хоёр төвтэй холбоотой хэвээр байж, дараах байдлаар дэмжин ажиллаж байна.

1/ Хөгжлийн дэмжлэг, хөдөлгөөн засалд туслах хүмүүсийг (төслийн сургалтад хамрагдан, төв дээрх дадлагуудад идэвхтэй оролцсон 1 хүн, төслийн орчуулагчийг (сувилагч мэргэжилтэй) сард нэгээс хоёр удаа төв рүү явуулах.

2/ Бие бялдар хөдөлгөөн заслын холбооноос санал болгосон хөдөлгөөн засалч болон хөдөлгөөн заслын ангийн 8 оюутныг сард нэг удаа төв рүү явуулж туслуулах.

3/ НИНЖИН-Өвсний үндэс өдрийн хоолны материалын зардлын зарим хэсэг, дээр дурдсан хүмүүсийн ажлын хөлсийг гаргаж байна.

Гэвч 2020 оны 2-р сараас цар тахлаас сэргийлэхийн тулд хоёр төвийн үйл ажиллагаа зогсож, өдгөө (2021 оны 3-р сарын байдлаар) ч нээгдээгүй байна. Төв дээр олноор цуглах боломжгүй болсон ч ХБХЭЭХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв зэрэг байгууллагаас зохион байгуулж буй онлайн сургалтуудад төвийнхөн болон эцэг эхчүүд хамрагдсаар байна.

Ийм нөхцөл дунд төсөл болон НИНЖИН ТББ-ын үйл ажиллагааны талаар улам олон хүнд таниулах зорилгоор энэхүү тайлан тэмдэглэлийг бэлтгэлээ.

Төслийн удирдагч,
Үмэмүра Киёора

2021 оны Гуравдугаар сар